



Сэтгүүлчийн эрхийн зөрчил

Дээд шүүхэд ялалт байгуулав

Улсын Дээд шүүх “Өвөрхангайн сонин”-ы эрхлэгч Б.Жавзансүрэнд холбогдох хэргийн анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болголоо.

Сэтгүүлч Б.Жавзансүрэн өөрийн эрхлэн гаргадаг “Өвөрхангайн сонин”-ы 2007 оны № 11-р /4-р сар/ дугаарт “Боловсролын дарга, хотын мэр нар Үдийн цай хөтөлбөрийг эзэрхийлжээ”, “Нийгмийн толь” сонинд “Өвөрхангайн дарга нар үдийн цайгаар хувийн унаагаа сэлгэжээ” нийтлэлүүддээ “...аймаг, сумын тодорхой албан тушаалтнууд Үдийн цай хөтөлбөрийг албан тушаалын давуу байдлаа ашиглан өөрсдөө хэрэгжүүлж байгаа...” талаар бичсэн байна.

Эдгээр сонинд уг нийтлэл гарсны дараа 2008.01.20-нд Арвайхээр сумын засаг дарга Т.Гончигдорж нэр төрөө сэргээлгэх, мэдээ тараагдсан хэлбэрээр залруулга гаргахыг хүссэн нэхэмжлэл гаргаснаар Б.Жавзансүрэнг хариуцагчаар татсан байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиудад зааснаар Б.Жавзансүрэн хариуцагч болох үндэслэлгүй, мөн нэхэмжлэгч өөрийн нэр төр гутаагдсан эсэхийг нотолж чадаагүй байтал Анхан шатны шүүх /2008.3.20/ нэхэмжлэлийг ханган шийдвэрлэснийг эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргасан боловч Өвөрхангай аймгийн давж заалдах шатны шүүх /2008.4.30/ шийдвэрийг хэвээр үлдээсэн юм. Дахин хяналтын шатны шүүхэд гомдол гаргаснаар Улсын Дээд Шүүхийн хуралдаанаар анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болголоо. Б.Жавзансүрэнд холбогдох дээрх иргэний хэрэгт “Глоб Интернэшнл” ТББ-ын хуульч Г.Даваахүү өмгөөлөгчөөр ажилласан юм.

Халдлагад өртсөн сэтгүүлчдэдээ туслав

УИХ-ын сонгуулийн үр дүнг эсэргүүцэгчдийн МАХН-ын байрны үүдэнд хийсэн жагсаал цуглаан, түүний дараа үүсэж бий болсон эмх замбараагүй байдлыг сурвалжилж байгаад халдлагад өртөж, эрүүл мэндээрээ хохирсон “Өнөөдөр” сонинны гэрэл зургийн сурвалжлагч Б.Бямба-Очир, МҮОНРТ-ын сурвалжлагч Д.Эрдэнэбулган нарт “Глоб Интернэшнл” ТББ тус бүр 100 000 төгрөг, НХХЯ-ны сайд, сэтгүүлч Т.Ганди Б.Бямба-Очирт 100 000 төгрөгийн тусламж үзүүллээ. Үймээний үеэр гэмтэж бэртсэн сэтгүүлчдийн тухай шуурхай мэдээг олон улсын сүлжээгээр түгээж Б.Бямба-Очирын хоёр дахь хагалгаанд зориулан хөрөнгө босгох аян зохион байгуулснаар гадаадын сэтгүүлчдийн байгууллагаас нийт 3000 евро, 1500 канад доллар олж хандивлаад байна. Үүнд: Олон улсын сэтгүүлчдийн холбоо, Норвег, Данийн сэтгүүлчдийн холбоо тус бүр 1000 евро, Канадын чөлөөт илэрхийллийн төлөө сүлжээний сэтгүүлчид 1500 канад доллар ирүүлсэн юм.

Дэлгэрэнгүй

<http://www.globeinter.org.mn/?cmd=Record&menuid=4>

Member of



www.ifex.org



www.internews.org



www.forum-asia.org

Мэдээ

“Глоб Интернэшнл” ТББ байр сууриа илэрхийлэв

2008 оны 7 сарын 1-ний өдрийн үйл явдлын улмаас Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевизээс бусад бүх өргөн нэвтрүүлгийн хэрэгслийн үйл ажиллагааг 4 хоногийн хугацаагаар түр зогсоосон Онц байдал зарлах тухай Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын зарлигийг эсэргүүцэж “Монголын Засгийн газар олон нийтийн үнэнийг мэдэх эрхийг үл тоомсорлон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд цагдан хяналт тогтоож буй нь үнэнийг хэлэх хэвлэл мэдээллийн эрхийг ноцтой зөрчлөө” гэж “Глоб Интернэшнл” ТББ мэдэгдсэн юм. Түүнчлэн МАХН-ын байрны өмнө болсон жагсаал, түүний дараа үүссэн хямралт байдлын үеэр телевизүүдийн хийсэн дүрс бичлэгийг Цагдаагийн Ерөнхий Газар иргэдийн эсрэг хөдөлшгүй нотлох баримт мэт ашиглаж буйг буруушаан мэдэгдэл гаргалаа.

Дэлгэрэнгүйг <http://www.globeinter.org.mn/?cmd=Record&menuid=4>

“Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хуулийн хэрэгжилтийн үр дүнг үнэлнэ

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хуулийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх ажлыг “Глоб Интернэшнл” ТББ, Нээлттэй нийгэм форумтай хамтран хийх санал тавьсаны дагуу ажлын хэсэг байгуулагджээ.

Ажлын хэсгийнхэн хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуультай холбогдсон харилцаанд оролцогч талуудын хуулиар хүлээсэн эрх, үүргийн биелэлтийн байдалд дүн шинжилгээ хийн зайлшгүй хяналт тавьж биелэлтийг гаргах шаардлагатай заалтуудын биелэлтийг гаргах бөгөөд уг хууль тогтоомж зөрчигчдөд хэрхэн хариуцлага хүлээлгэж байгаа үйл ажиллагаатай танилцана. Ажлын дүнг ХЗДХЯ-ны удирдлагад танилцуулан хуулийн хэрэгжилтийн явцыг эрчимжүүлэхтэй холбогдуулан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж гаргана.

Монгол улсад Олон Нийтийн Радио Телевизийг хэрхэн хөгжүүлэх талаар ярилцав

МҮОНРТ, Ази-Номхон далайн Өргөн нэвтрүүлгийн хөгжлийн хүрээлэн/ AIBD/ НҮБ-ын Боловсрол соёл шинжлэх ухааны байгууллага /UNESCO/ хамтран “Монгол улсад Олон Нийтийн Радио Телевизийг хөгжүүлэх нь” сэдэвт дугуй ширээний уулзалт, сургалт, семинар зохион байгууллаа.

“Парламентын хэлэлцүүлгийг шууд дамжуулахад анхаарах зүйлс” сэдэвт дугуй ширээний уулзалтын үеэр Энэтхэг, Иран, Франц, Скандинавын орнуудын жишээн дээр парламентийн хэлэлцүүлгийг хэрхэн шууд дамжуулдаг туршлагатай танилцан Монгол оронд ийм төрлийн дамжуулалт хийхийн эерэг, сөрөг талуудын талаар санал солилцов.

Монголын сэтгүүлчдийн их хурал болно

Монголын сэтгүүлчдийн III их хурал 2008 оны 11-р сарын 6-ны өдөр Чингис зочид буудалд болно. Их хурлаар Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж зохион байгуулалтын асуудал хэлэлцэхээр төлөвлөж байна. Их хуралд Улаанбаатар хот, орон нутгийн сэтгүүлчдийн салбарыг төлөөлсөн 130-аад сэтгүүлч оролцоно.



Гэрэл зургийн сурвалжлагч Б.Бямба-Очирын эмчилгээний зардалд хандив өргөхийг уриалж байна

“Глоб Интернэшнл” ТББ-ын санаачилсан “Өнөөдөр” сонины гэрэл зургийн сурвалжлагч Бямбасүрэнгийн Бямба-Очирт зориулсан хөрөнгө босгох кампанит ажил үргэлжилж байна.

Б.Бямба-Очир 2008 оны сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөөгүй намуудын дэмжигчдийн жагсаал олныг хамарсан эмх замбараагүй байдалд шилжих үед мэргэжлийн үүргээ гүйцэтгэж яваад халдлагад өртөж яаралтай хагалгаанд орсон хэдий ч цаашид урт хугацааны эмчилгээг гадаадын аль нэг улсад хийлгэхэд 40000 орчим ам.доллар шаардагдаж байна.

Б.Бямба-Очир нь 2005 оноос өдөр тутмын “Өнөөдөр” сонинд ажиллаж байгаа бөгөөд Батзоригийн нэрэмжит фото зургийн уралдааны 2007 оны тэргүүн, 2008 оны 2-р байрын шагналт, 2007 оны “Глобализм” фото зургийн уралдааны тусгай шагналт авъяаслаг залуу уран бүтээлч юм. Б.Бямба-Очир 23 настай, гэр бүлгүй, ээж, дүүтэйгээ амьдардаг. Дунд сургуулийн багш ээж нь түүний цаашдын эмчилгээний төлбөрийг төлөх боломжгүй бөгөөд Солонгос улсад тусламж хүсч хандаад байна.

“Глоб Интернэшнл” ТББ Б.Бямба-Очирын хагалгааны зардалд хандив өргөхийг гадаадын сэтгүүлчдэд хандан олон улсын сүлжээгээр түгээж хөрөнгө босгох аян зохион байгуулснаар нийт 3000 евро, 1500 канад доллар олж хандивласан. Үүнд: Олон улсын сэтгүүлчдийн холбоо 1000 евро, Норвегийн сэтгүүлчдийн холбоо 1000 евро, Данийн сэтгүүлчдийн холбоо 1000 евро, Канадын чөлөөт илэрхийллийн төлөө сүлжээний сэтгүүлчид 1 500 канад доллар тус тус ирүүлээд байна.

Иймд Сэтгүүлч Б.Бямба-Очирын эмчилгээний зардалд хандив өргөхийг иргэн, аж ахуйн нэгж байгууллага, мэргэжил нэгт хамт олонд нь хандан Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, сэтгүүлчийг эрхийг хамгаалан ажилладаг “Глоб Интернэшнл” ТББ уриалж байна.

Хандивын данс:

Төгрөгийн ХААН банк 5029581509

Долларын ХААН банк 5077040970

“Оюуны дархлаа” ТББ үйл ажиллагаагаа эхэллээ



“Мэдлэг бол бидэнд байгаа хамгийн найдвартай вакцин” гэсэн уриаг удирдлага болгосон “Оюуны дархлаа” ТББ сэтгүүлчдээр дамжуулан нийгмийн эрүүл мэндийн мэдлэг, мэдээллийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлж чаддаг

оюун санааны дархлаатай иргэдийг бий болгох хэтийн зорилгыг өмнөө тавьжээ.

Тус байгууллага ХДХВ/ДОХ-ын Үндэсний хороо, ДОХ-ын Үндэсний сан, Глобал сан, НҮБ-ын Хүн амын сан зэрэг гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах эхлэлийг тавьж Австралийн Улаан загалмайн нийгэмлэгийн санхүүжилтээр МУЗН-тай хамтран “Сэтгүүлчид ХДХВ/ДОХ-ын эсрэг” төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Төслийн хүрээнд сэтгүүлчдийн дунд сургалт, дугуй ширээний уулзалт зохион байгуулахын зэрэгцээ сонин, хэвлэлийн нийтлэлд судалгаа хийж байна.

7-р сарын 1-ний үймээнийг ХМХ-үүд хэрхэн тусгасан бэ?

2008 оны 7-р сарын 1-нд болсон жагсаал цуглаан, түүний дараа үүссэн хямралт байдлын үеэр буюу 7-р сарын 1-нээс 9-нийг дуустал ес хоногийн хугацаанд хэвлэл мэдээллүүд тухайн үйл явдлыг хэрхэн тусгасан, тэдний хүний эрхийн асуудлаарх хандлагыг судлах, зөрчилдөөнт үйл явдлыг шийдвэрлэхэд хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох зорилгоор “Хүний эрхийн зөрчлийн мониторинг” төслийг хэрэгжүүлэв. Хүний эрхийн төрийн бус байгууллага, хуульчдын оролцоотой санал солилцсоны үндсэн дээр судалгааны арга зүйг боловсруулан 11 телевиз, өдөр тутмын 3 сониныг хамруулсан бөгөөд мэдээллийг нэгтгэн тайлан бэлтгэж байна.

Сонгуулийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мониторинг хийв

2008 оны УИХ-ын сонгуулийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслүүд аль хэр шударга, тэнцвэртэй мэдээлэл түгээж буйг үнэлэх зорилгоор 2008 оны 03-р сарын 14-ний өдрөөс 04-р сарын 04-ний өдрийг хүртэлх гурван долоо хоногийн хугацаанд өдөр тутмын 12 сонинд мониторинг хийв.

Конрад Адэнаурын сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн энэ төсөл нь анх удаа албан ёсны сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийснээр онцлогтой байв. Төслийн хугацаанд улс төрийн намуудын тавьж буй улс төр, нийгэм, эдийн засгийн гол гол асуудлыг болон болзошгүй нэр дэвшигчдийн нэр, тэдний нийгэмд илгээж буй мессежийг тодорхойлсон төдийгүй сонгуулийн албан ёсны кампанит ажлын үеэр ямар өөрчлөлт гарсныг харьцуулан дүгнэх боломжтой болсон юм. Дэлгэрэнгүй тайланг

<http://globeinter.org.mn/?cmd=Record&menuid=4>

Сонгуулийн сурталчилгаанд ХМХ-ийн гүйцэтгэсэн үүргийг дүгнэв

2008 оны УИХ-ын сонгуулийн ухуулга сурталчилгаа албан ёсоор эхэлсэн 06-р сарын 02-ны өдрөөс кампанит ажил дуусах өдөр хүртэл хугацаанд 6 телевиз, 1 радио, өдөр тутмын 3 сонин, 7 хоног тутмын 2 сонинг сонгож сурталчилгааны тэнцвэрт, шударга байдал, сонгуулийн хуулийн хязгаарлалт, далд сурталчилгааны байдал гэсэн гурван чиглэлээр хийв. Дэлгэрэнгүй тайланг

<http://globeinter.org.mn/?cmd=Content&id=729&menuid=335>


Сонгуулийн үеэр улс орны хөгжлийн асуудлыг хэвлэл мэдээлэл хэрхэн тусгаж буйг судлав

Монголын хэвлэл мэдээлэл сонгуулийн үеэр улс орны хөгжлийн тулгамдсан гол асуудлыг хэрхэн тусгаж байгаад анх удаа мониторинг хийлээ.

Мониторингийн баг сонгуулийн сурталчилгааны явцад монголын телевизүүд хөгжлийн асуудлаар сонгогчдод мэдээлэл түгээсэн эсэх, тэдгээр асуудлаар мэтгэлцээн бэлтгэсэн эсэх, бэлтгэсэн бол мэргэжлийн түвшин нь ямар байсныг тодруулахаар ажилласан бөгөөд сэтгүүлч, мэргэжилтнүүдийн алдаа оноог илрүүлэн шүүмжлэхээс илүү цаашдын ажилд нь тэс нэмэр болно гэх үүднээс хандсан юм. Тайлангаас мэтгэлцээний сонгодог загвар, хэлбэр, бүтэц, стандарт, зарчмын тухай зарим мэдээллийг авах боломжтой. Тайлангийн дэлгэрэнгүйг

<http://globeinter.org.mn/?cmd=Content&id=729&menuid=335>

“Глоб Интернэшнл” ТББ-аас 2008 оны 6-р сарын 7-ноос 9-ний өдрүүдэд Кемпинский зочид буудалд “Телевизээр сонгуулийн



мэтгэлцээн хэрхэн зохион байгуулах вэ?” сургалт зохион байгуулсан юм. Интерньюс Украин олон улсын байгууллагын сургагч багш Дмитрий Крикуны удирдсан энэ сургалтанд “25-р суваг” телевиз, МҮОНТ, NTV, ТМ, Ийгл, Боловсрол зэрэг телевизийн сэтгүүлчид, Их дээд сургуулиудын сэтгүүл зүйн багш нар нийт 22 хүн оролцсон бөгөөд сургалтын материал дээр үндэслэн “Телевизээр сонгуулийн мэтгэлцээн хэрхэн зохион байгуулах вэ?” гарын авлага гаргасан байна.

Гарын авлага: <http://globeinter.org.mn/images/upld/Handbook.pdf>



Сэтгүүлчидтэй холбогдсон хэрэг, маргааныг хэрэг үүсгээгүй байхаасаа эхлээд л шүүх, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах зэрэг ажиллагааны аль ч үед эх сурвалжаа илчлэхийг шаардах нь энгийн үзэгдэл болсон учир энэ удаагийн хуулийн зөвлөгөө булангаараа эх сурвалжтай холбоотой асуултуудад хариулт өгье.

Мэдээллийн эх сурвалж гэж юуг ойлгох вэ? Бүх эх сурвалжийг нууцлах боломжтой юу?

Аливаа мэдээ, мэдээлэл, баримт сэлтийг агуулж байгаа бүхий л эх үүсвэрийг сэтгүүл зүйд эх сурвалж гэж ойлгож болно. Тэгэхээр эх үүсвэр бүрийг нууцлах боломжгүй буюу шаардлагагүй юм. Сэтгүүл зүйд аль болох мэдээллийн эх сурвалжийг ил тод байлгах зарчим баримталдаг. Учир нь нийтэлж, нэвтрүүлж буй зүйлд уншигч, сонсогчийн зүгээс итгэх итгэл төдий хэмжээнд нэмэгдэж байдаг гэж үздэг. Сэтгүүл зүйн нийгэмд гүйцэтгэх хяналт “хоточ нохой”-н үүргээс үүдэн мэдээллийн эх сурвалж хамгаалалт буюу өвөрмөц зохицуулалт шаардаж эхэлдэг. Ингэхээр зарим эх сурвалжийг нууцлах шаардлагатай болдог.

Хэнээс мэдээлэл авснаа сэтгүүлч та хэлэх ёстой юу?

Сэтгүүлчдийн цорын ганц онцгой үүрэг нь нууц эх сурвалжийг хамгаалах гэж үздэг. Энэ нь сэтгүүлчид өөртөө олгосон эрх, статус биш. Өөрөөр хэлбэл, мэдээлэл өгсөн этгээд нь тухайн мэдээллийг сэтгүүлчид олон нийтийн сайн сайхны төлөө сэтгүүлчид өгсөн нь тухайн хувь хүний амь нас, эрүүл мэнд, гэр бүлийн халдашгүй байдал зэрэгт ноцтой хохирол учруулахуйц аюул занал авчрахаар байвал сэтгүүлч түүнийг илчлэхгүй байх үүрэг хүлээдэг. Дэлхий даяар сэтгүүлчид өөрсдөд нь нууц байдлаар мэдээлэл өгдөг хүмүүсийг хамгаалахыг эрмэлздэг. Олон нийттэй, сэтгүүлчидтэй ярилцсанаа төлөө ноцтой үр дагавар бүхий эрсдэлтэй тулгарч буй болон тулгарч болзошгүй тэр мэдээлэгчийн өмнө хүлээсэн үүрэг гэж үздэг.

Мэдээллийн эх сурвалжийг хамгаалах асуудлыг манай улсад хэрхэн хуульчилсан бэ?

Монгол Улсад мэдээллийн эх сурвалжаа хамгаалах тухай тусгай хууль өнөө хэр нь байхгүй байна. 2005 онд батлагдсан Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 34.2 дугаар зүйлд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгосноос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй” гэж заасан. Гэхдээ энэхүү заалт Олон нийтийн радио, телевизийн сэтгүүлчдээс бусад хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдэд хамаарахгүй. Иргэний эрх зүйн зарчмын үүднээс авч үзвэл уг заалтыг төсөөтэй хэрэглэх боломжтой байж болно. Энэхүү заалтыг хэрхэн хэрэглэх тухай УДШ-ийн албан ёсны тайлбар шаардлагатай юм.

Шинэ ном



МУСГЗ, нэрт сэтгүүлч Хорлоогийн Цэвэлзэгийн “Нийтлэл зүйн тухай яриа” хэмээх бодрол нийтлэлийн хураангуй ном хэвлэгдэн гарлаа. Шинжлэлт сэтгүүл зүйн чиглэлээр олон даацтай бүтээл туурвисаар ирсэн ахмад сэтгүүлчийн энэ ном “Амьдрал бидэн хоёр”, “Сэтгэлийн өчил”, “Зүрхний бичээс”, “Миний сэтгүүл зүй”, “Хөх утаа”, “Өвөөгийн жор” зэрэг олон бүтээлийнх нь нэг юм.

Хуульч зөвлөж байна.



Сэтгүүлч таны эрх зөрчигдөж эрх зүйн туслалцаа хэрэгтэй болбол “Глоб Интернэшнл” ТТБ-ын хуульч Д.Мөнхбүрэнд burnee@globeinter.org.mn хаягаар хандаарай.

Утас: 324627, 324764

Мэдээллийнхээ эх сурвалжийг илчлэхийг шаардвал яаж та өөрийгөө хамгаалах вэ?

Хэдийгээр хуульчилсан байдал хангалтгүй ч сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн зарчмуудад орсон заалтуудыг баримтлан ажиллах бололцоотой юм. Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооноос баталсан Сэтгүүлчийн баримтлах зарчимд “Итгэл хүлээж олж авсан мэдээллийн уг сурвалжтай холбогдох мэргэжлийн нууцыг сэтгүүлч хадгалж байх” гэж заасан байдаг. Мөн 9-р зүйлд нь “Сэтгүүлчид эрхэм нэр төрдөө эзэн болж, дээрх зарчмуудыг ёсчлон биелүүлэхийг өөрсдийн үүрэг гэж үзвэл зохионо...” гэсэн байна. Түүнчлэн “Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн 2005 оны гуравдугаар сарын 11-ний өдөр баталсан “Монголын Сэтгүүлчдийн баримтлах зарчим”-ын 4 дэх зүйлд “Хүний итгэлийг хүлээж олсон мэдээллийнхээ эх сурвалжийг ямар ч тохиолдолд чанад нууцална” гэж заасан. 1987 оны “Чөлөөт хэвлэлийн Харти”-д тунхаглахдаа ч чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийг дэмжихэд зайлшгүй байх зарчмын нэгийг нь гэдгийг хүлээн зөвшөөрсөн билээ. Иймд сэтгүүлч мэдээллийнхээ эх сурвалжийг зааж өгөхгүй байх нь түүний ёс зүйн үүрэг, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн онцгой үүрэг, хариуцлагын асуудал юм.

Мэдээллийнхээ эх сурвалжийг илчлээгүйн төлөө хариуцлага хүлээх үү?



Эх сурвалжаа илчлэхгүй бол хариуцлага хүлээлгэх, хорино, цагдана гэх мэтээр сүрдүүлэх нь манайд байгаа нийтлэг сөрөг хандлага юм. Та мэдээллийн нууц эх сурвалжаа зааж өгөх нь сэтгүүлчийн ёс зүйд харш үйлдэл болохыг тайлбарлах, хуульчаас зөвлөгөө авч ажиллах хэрэгтэй. Үүгээр ч барахгүй энэ сүрдүүлэг нь сэтгүүлч таны эрхийг зөрчсөн хууль бус үйлдэл гэж үзвэл та гомдол гаргаж, шийдвэрлүүлэх боломжтой.

Сэтгүүлч та нууц эх сурвалжаа илчилбэл ямар эрсдэл хүлээх вэ?

Итгэл хүлээлгэсэн мэдээлэгчийн нууц байдал алдагдвал чухал мэдээлэлтэй эх сурвалжид аюул занал учрах магадлал маш их. Хэрэв нэг л мэдээлэгчийг илчилбэл бусад чухал мэдээлэл бүхий хүн танд болон сэтгүүлчдэд хандахаас татгалзаж, мэдээлэл нууц байдалд орно. Ингэснээр ардчилсан нийгэмд хортой үр дагавар авчирч, хэвлэл мэдээлэл нь ямагт мэдээлэл хүсдэг олон нийтийн хэрэгцээг хангаж чадахаа больж, сэтгүүлч та хараат бус байх боломжгүй болно.

Ер нь мэдээллийн эх сурвалжтай холбоотой харилцааг бусад орнуудад хэрхэн зохицуулдаг вэ?

Улс орнуудын эрх зүйн тогтолцоо, шүүхийн практик, хэвлэл мэдээллийн чөлөөт байдал болон бусад олон хүчин зүйлээс хамааран өөр өөрөөр зохицуулсан. Тухайлбал, Австри, Бельги, Кипр, Финлянд, Герман, Швед, Америк зэрэгт эх сурвалжийг хамгаалсан эрх зүйн зохицуулалт нэлээд сайтай гэгддэг. АНУ-ын 50 мужийн 33-д нь ийм хууль байдаг бөгөөд хуулийн байгууллагын өмнө ч эх сурвалжаа илчлэхгүй байж болдог байна. Зарим орнууд эрүүгийн хууль, Мэдээллийн эрх чөлөөний хууль, Хэвлэл мэдээллийн хууль зэрэгтээ эх сурвалжийн хамгаалалтыг оруулсан байна.

Шилдэг бичлэгийн уралдаан

Нийт сэтгүүлчдийн дунд олон улсын ДОХ-ын эсрэг өдрийг тохиолдуулан “Үнэнийг мэдье, үзэн ядалтыг зогсооё” гэсэн шилдэг бичлэгийн уралдааныг 2008 оны аравдугаар сарын 15-наас арваннэгдүгээр сарын 25-ны хугацаанд зарлаж байна.

Уралдааны зорилго нь:

ХДХВ/ДОХ-ын тухай үнэн, зөв мэдээллийг олон түмэнд түгээн дэлгэрүүлэх, халдвараас урьдчилан сэргийлэх арга замыг тайлбарлан ойлгуулах, нэгэнт халдвар авсан хүмүүсийн эрх ашгийг хамгаалах, тэднийг ялгаварлан гадуурхахгүй байх хүмүүнлэг, иргэний зарчмыг баримталсан байх шаардлагатай. Түүнчлэн ХДХВ/ДОХ-ын талаар төр, засаг, олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс ямар ажил хийх нь зүйтэй болох талаар тодорхой санал дэвшүүлж болно.

Бичлэгийн төрөл зүйл /жанр/ ямар ч байж болно. Уралдаанд ирүүлсэн бүтээл нь дээр дурдсан хугацаанд сонин хэвлэлд нийтлэгдсэн байх ёстой.

Уралдааныг дүгнэх:

Нэгдүгээр байр	1: өргөмжлөл	300,000 төгрөг
Хоёрдугаар байр	2: өргөмжлөл	200,000 төгрөг
Гуравдугаар байр	3: өргөмжлөл	100,000 төгрөг
Тусгай шагнал	5: өргөмжлөл	Үнэ бүхий зүйл

Уралдаанд ирүүлэх бүтээлийг 2008 оны 11 сарын 25-ны дотор Монголын Улаан загалмайн нийгэмлэг, Оюуны дархлаа ТББ-д хүлээн авч арваннэгдүгээр сарын 30-нд дүнг гаргана.

Холбоо барих утас:

312578, 99033575, 99773800, 88110413

“ОЮУНЫ ДАРХЛАА” МОНГОЛЫН УЛААН
ТӨРИЙН БУС ЗАГАЛМАЙН
БАЙГУУЛЛАГА НИЙГЭМЛЭГ

Шинэ ном



МУИС-ийн сэтгүүл зүйн багш, докторант Д.Батжаргал “Сэтгүүл зүйн бичлэгийн нэр томъёоны товч тайлбар толь” гаргажээ. Тайлбар толийг орчин цагийн суурь сэтгүүл зүйг иш үндэс болгон бичгийн их хүмүүс, зохиолчдын хэлэлцдэг зарим нэр томъёог оруулж практик зөвлөмжинд түшиглэн бичсэн нь сонирхолтой болжээ.

Хэзээ, хаана, юу?

Оксфордын Их Сургууль сэтгүүлчдийг 2009/10 оны тэтгэлэгт хөтөлбөрт урьж байна

Оксфордын Их Сургуулиас ажиллаж буй сэтгүүлчдэд зориулсан нэгэн онцгой тэтгэлэгт хөтөлбөр зарлажээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд дэлхийн өнцөг булан бүрийн сэтгүүлчид Оксфорд дахь Ройтерс Институт дээр гурваас есөн сарын хугацаанд сонгосон сэдвийнхээ дагуу судалгаа хийж, мэргэжлийн хүмүүсээс зөвөлгөө авч, Оксфордын Их сургуулийн орчин, амьдралтай танилцах боломжтой байх аж. Уг хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн зэрэг цол ахиулах боломжгүй боловч сэтгүүлчдэд сонирхсон салбарынхаа хүрээнд шинжлэх ухааны судалгаа хийх боломж олгож буйгаараа онцлог. Дэлгэрэнгүй мэдээллийг

<http://reutersinstitute.politics.ox.ac.uk/fellowships/overview.html>

Сэтгүүл зүйн бичлэгийн үндсэн төрөл зүйлээр цуврал сургалт зохион байгуулна.

Сэтгүүлчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор сэтгүүл зүйн бичлэгийн үндсэн төрөл зүйлээр цуврал сургалт зохион байгуулж төгсөгчдөд сертификат олгоно.

Сургалтын сэдэв

Суурь сэтгүүл зүй:

- Мэдээ /Сонин, радио, телевиз, цахим хэвлэл/
- Сурвалжлага, хөрөг / Сонин, радио, телевиз /
- Ярилцлага /Сонин, радио, телевиз/
- Өгүүлэл, нэвтрүүлэг /Сонин, радио, телевиз/
- Редакцийн өгүүлэл /Сонин, радио, телевиз/
- Эрэн сурвалжлах сэтгүүл зүй
- Ёс зүй
- Сонины дизайн
- Фото сэтгүүл зүй

Мэргэшсэн сэтгүүл зүй:

- Улс төрийн асуудлыг хэрхэн сурвалжлах вэ?
- Эдийн засгийн асуудлыг хэрхэн сурвалжлах вэ?
- Байгаль орчны асуудлыг хэрхэн сурвалжлах вэ?
- Шүүхийн асуудлыг хэрхэн сурвалжлах вэ?
- Шинжлэх ухааны асуудлыг хэрхэн сурвалжлах вэ?
- Сонгуулийн асуудлыг хэрхэн сурвалжлах вэ?
- Дижитал технологийн тусламжтай эвлүүлэг хийх

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.pressinst.org.mn>

Хэвлэл мэдээлэлтэй хэрхэн үр дүнтэй харилцах вэ? сургалт

Монголын Хэвлэлийн Хүрээлэн байгууллагуудын маркетингийн болон олон нийттэй харилцах менежер, ажилтнуудад зориулсан нэг өдрийн сургалтыг энэ оны 10-р сарын 30-нд зохион байгуулах гэж байна.

Нэг өдрийн дотор хэвлэл мэдээлэлтэй холбоотой бүхий л мэдээллийг олгох зорилготой энэхүү сургалтанд оролцогчдыг Хэвлэлийн Хүрээлэн дээр бүртгэж байна. Оролцогчдын тоо хязгаартай.

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.pressinst.org.mn>

Улаанбаатар хот. Чингэлтэй дүүрэг VI хороо, Эрх чөлөөний талбай,

Дипломат 95 цогцолбор, 06 тоот.

Утас: 324627, 324764, Факс: 324764, 315326

E-mail: hnanan@globeinter.org.mn, globe@globeinter.org.mn, globenews@globeinter.org.mn